

**Өдөр тутмын амьдралаас зам мөрийг эрэлхийлэх**  
**Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч**  
**Нивано Ничикоо**



**Шашны Энх Тайвны Чуулгын 50 жилийн ой: Үүсгэн байгуулагчийн хүсэл зорилгыг эргэн харахад сэтгэл маш их хөдөлсөн**

“Рэйва” эрин үеийн анхны жилийг угтлаа. Хүн болгонд сэтгэлдээ бодсон төлөвлөсөн зүйл байгаа болов уу гэж бодож байна.

Өнгөрсөн жил 15, 19-р хар салхи зэрэг байгалийн гамшиг удаа дараалан болж, олон хүн нэрвэгдсэн. Гэр орон, тариан талбайд нь хохирол учирсан хүн, тог ус тасарснаас болж хэцүү нөхцөлд амьдрахаас өөр аргагүй болсон хүн, мөн одоо хүртэл амьдралаа дахин босгох аргаа олохгүй байгаа хүн ч олон бий. Тэдгээр хүмүүсийн төлөө дахин залбирч, үүсээд буй нөхцөл байдлыг хурдан даван туулахыг хүсэн ерөөе.

Япон байгалийн гамшиг ихтэй орон. Тиймээс хүн бүр өнөөг хүртэлх туршлагадаа тулгуурлан зайлшгүй тохиолдолд хэрхэх арга ухааныг бодож олох шаардлагатай гэж бодож байна. Өөрийнхөө аюулгүй байдлыг хангах (онцгой байдлын үед хэрэглэх зүйлсийг бэлдэж, орон нутгийнхаа гамшигийн эрсдэлийг тооцох гэх мэт), хүмүүсийн аюулгүй байдалд анхаарах (ойр орчмын хүмүүс хоорондоо харилцан туслалцах) хоёрыг хоёуланг нь чухалчилж, аль болох бага

## New Year's Message 2020

гарз хохирол гаргахын төлөө үргэлж бэлтгэлээ базааж байх хэрэгтэй.

Ялангуяа сүүлийн жилүүдэд гарч буй байгалийн гамшиг нь дэлхийг хамарсан цаг уурын дулаарлын нөлөөгөөр улам ноцтой болж байна. Иймэрхүү цаг уурын өөрчлөлтөд хүмүүсийн хийж буй үйлдэл ихээхэн нөлөөлж буй гэгдэж байгаа. Япон улс баян тансагийн хажуугаар хэт их үйлдвэрлэл, хэрэглээ, устгалыг хийсээр байна. Өнөөг хүртэлх тогтсон хэм хэмжээндээ өргөн цар хүрээтэй өөрчлөн шинэчлэлт хийх үе ирээд байна гэж бодож байна.

Нөгөөтэйгүүр өнгөрсөн жил WCRP (Дэлхийн Шашны Энх Тайвны Чуулган)-ын 10-р их чуулган Германд болсон. WCRP энэ жил 50 жилийн ойтойгоо золгож байгаа. Тус чуулганы үүсэл, хөгжил дэвшил нь Үүсгэн байгуулагчийн том зорилго байсан. Энэ замнал хагас зууны турш үргэлжилсэн гэхээр сэтгэл ихэд хөдөлж байна.

10-р чуулган Германы гадаад явдлын яамны удирдлага, оролцоотойгоор зохион байгуулагдсан. Мөн жил ирэх тусам зөвхөн шашны байгууллага төдийгүй олон улсын засгийн газар, НҮБ зэрэгтэй харилцаагаа батжуулж, цар хүрээ нь өргөжин тэлсээр байна. Үүсгэн байгуулагч болон олон ахмад үеийнхэн маань баярлаж байгаа нь гарцаагүй.

Дэлхийн чуулган болох хугацаанд Их ариун ордон болон орон даяарх бүх салбар нийгэмлэгүүдэд гишүүд залбиралын ном уншсан. Миний бие та бүхний хүслийг тээн, итгэл төгс дэлхийн чуулганд оролцсон.

Энх тайвныг бий болгоход дэлхийн хэмжээний, мөн мэргэжлийн түвшний хэлэлцүүлэг, үйл ажиллагаа шаардлагатай байгаа нь үнэн. Гэхдээ хамгийн үндсэн чухал зүйл бол өөрийн улс орон, бүс нутаг, гэр бүлдээ энх

тайвныг бий болгох явдал юм. Үүний тулд гэр бүлийн хүрээнд шашны сургаалд тулгуурласан уужуу тайван сэтгэл, хүнлэг чанарыг өсгөн хүмүүжүүлэх шаардлагатай. Энэ утгаараа сүсэг бишрэл бүхий амьдрал энх тайвантай шууд холбоотой гэдгийг өнөөдөр дахин бодож үзүүштэй.

Мөн энэ жилийн 8-р сард Токиод хоёр дахь удаагаа олимп болж, гадаадаас олон хүмүүс ирцгээнэ. Токио төдийгүй орон даяар айлчлан ирэх жуулчдын тоо энэ жил 30-40 саяд хүрнэ гэгдэж байна. Тэдгээр хүмүүст Япон орны сайхан талыг харуулахын төлөө гэгээлэг, эелдэг, зөөлөн дулаан сэтгэлээр харилцаж, чадах чинээгээрээ хувь нэмэр оруулцгаая.

### Байгаа газар бүгд зам мөрийн газар Өдөр тутмын үйл хэрэг бүгд бурханы үйл

Ингээд би “Рэйвагийн 2-р оны зорилт”-ыг дараах байдлаар тодорхойллоо.


Тэнгэр газар, байгаль дэлхий хором мөч бүрт бүтээн байгуулалт, өөрчлөлт шинэчлэлтийг хийж байдаг. Бид ч гэсэн энэхүү байгаль дэлхийн зохилдлогооны дагуу нэг газраа зогсолгүй, аливаа зүйлд үргэлж шинэлэг сэтгэлээр хандах чухал.

Энэ жил манай байгууллага 82 жилийн ойтойгоо золгоод байна. Энэ хүртэлх түүх Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан болоод ахмад лидерүүд, гишүүд нойр хоолоо хасан хичээж зүтгэсний ачаар сүндэрлэн боссон. Бид цаашид байгууллагын 100 жилийг зорин хүн бүхэн “Энэ газар бол зам мөрийн газар болой” гэсэн зарчмаар тэдний ачийг хариулахыг уриалж байна.

Жил бүрийн “Зорилт”-ыг илүү гүнзгий бататгах гэдэг үүднээс 3 жил бараг адилхан зүйлийг хэлж байгаа. Энэ жилийн хувьд «“Энэ газар бол зам мөрийн газар болой” гэсэн зарчим» гэсэн үгийг шинээр нэмсэн.

Цэнхэр судрын эхэнд “Бясалгал үйлдэн гэгээрэх замууд” хэсэгт энэ үг гардгийг та бүхэн мэдэж байгаа.

“Зам мөрийн газар” гэхээр хамгийн түрүүнд Их ариун ордон, нийгэмлэг, орон нутгийн хэсэг санаанд ордог. Гэхдээ “Энэ газар бол зам мөрийн газар болой” гэдэг нь байгаа газар, амьдарч буй газар бүгд зам мөрийн газар гэсэн утгатай.



Би сүмоогоор их жишээ татдаг. Нийгэмлэг, хэсэг нь дасгал сургуулилт хийх газар гэж хэлж болно. Харин жинхэнэ барилдаан болох газар нь гэр бүл, ажлын газар, сургууль, нийгэм юм.

Өдөр тутмын амьдралд янз бүрийн зүйл тохиолддог. Хувиа хичээсэн хүн ч байдаг болохоор бие биенээ ойлгож, эв зетэй байна гэдэг амар зүйл биш.

Зан ааш таарахгүй хүнтэй учрах, хүйтэн ширүүн үгээр хэлүүлэх, үл тоох гээд гунигтай, хэцүү санагдах үе ч гарна.

Гэхдээ хүн гэдэг эрх чөлөөгүй, санасныхаа зоргоор байж чадахгүй байх тусмаа түүнийг ямар нэгэн аргаар даваад гарах юмсан гэж боддог. Ямар ч сорих зүйлгүй бол хүн бараг л өсөж хөгжихгүй болов уу.

Тийм болохоор бэрхшээлтэй тулгарсан үедээ “Хүний хувьд өсөж хөгжих боломж гарч ирлээ”, “Одоо л яг хийх үе ирлээ” хэмээн хүлээн авч, тулгараад байгаа зүйлийнхээ төлөө хамаг хүчээ зориулах нь “Энэ газар бол зам мөрийн газар болой” гэсэн зарчим юм.

Ялангуяа лам биш эгэл жирийн буддын шашинтан хүний хувьд өдөр тутмын амьдрал тэр чигээрээ бурханы үйл хэрэгжүүлэх газар байдаг. Ямар нэг зүйлийг тусгайлан хийх шаардлагагүй. Хүнтэй уулзаж ярилцах, ажил хийх, сургуульд явах, хоол, цэвэрлэгээ хийх зэрэг хийж байгаа зүйлээ хагас дутуу хийлгүй, нямбай, сэтгэл гарган хийснээр зөв дадал зуршил биед сууж, бие сэтгэл аяндаа зүгширээд ирдэг.

Гэтэл бид эрх дураараа, хувиа хичээсэн зан чанараа ялангуяа гэр орондоо гаргах нь элбэг. Гэр бүлийнхэн бол хамгийн ойр дотно хүмүүс болохоор биеэ барилгүй нууж хаалгүй хатуу үг хэлж орхих үе бий.

Ийм нөхцөл байдалд сэтгэл хөдлөлөө дарж, хувийн үзэл бодлоо хаяж, бурханы сургаалыг хэрэгжүүлнэ гэдэг хамгийн хэцүү үйл юм. Тийм болохоор л гэр бүл нь “хүнийг хөгжүүлэх үндсэн зам мөрийн газар” болдог учиртай.

Эдогийн эхэн үеийн Зэн буддизмын Ринзаи урсгалын ламтан Шидоо Мүнан дараах сургамжит дууг бичиж үлдээсэн байдаг.

“Зам мөр гэдэг үгэнд төөрөлдөх болохгүй

Өглөө, орой өөрийгөө сорих мэх гэдгийг мэдвэл зохилтой”

Энэ нь “Бурханы зам мөр гэхээр их л мундаг бөгөөд хэцүү зүйл мэт сонсогддог боловч тэр

үгэнд төөрөлдөж болохгүй. Таны өглөө, орой буюу өдөр тутамдаа хийдэг зүйл өөрөө бурханы үйл гэдгийг мэдэх хэрэгтэй” гэсэн утгатай. “Энэ газар бол зам мөрийн газар болой” гэдгийг маш тодорхой илэрхийлсэн дуу гэж бодож байна.

### Өөрөөсөө улдаар бусад хүмүүсийг аз жаргалтай болгох юмсан гэсэн сэтгэл хүн бүрт төрөлхийн байдаг

Тэгвэл бурханы сургаалыг хэрэгжүүлнэ гэдэг юу хийхийг хэлж байгаа юм бол?


Манай байгууллага Лянхуа судрыг гол судраа хэмээн үздэг. Лянхуа судрын хамгийн гол сургаал бол “Бодьсадвагийн үйл” юм.


Өөрөө гэгээрлийг олохыг хүсэхийн зэрэгцээ бусад хүмүүсийг ч гэсэн аз жаргалтай болгох юмсан гэсэн сэтгэлтэй хүнийг “Бодьсадва” гэдэг. Хэзээ ч, ямар ч үед тэр сэтгэлээ марталгүй зам мөрд хичээхийг “Бодьсадвагийн үйл” гэнэ. Ойлгомжтой хэлэх юм бол, бурханы сургаалыг сурч, өөрийн болгож, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй байхыг хэлнэ.

“Өөрөө хараахан гэгээрээгүй ч гэсэн эхлээд бусад хүмүүсийг гэгээрэхэд туслах” гэсэн үг байдаг. Өөрөө гэгээрэлд хүрье гэхээсээ улдаар бусад хүмүүсийг гэгээрэлд хүргэх юмсан гэсэн сэтгэлээр сургаалыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн утга. Энэ нь бодьсадвагийн үйлүүд дотор бүр ч эрхэм гэгддэг.

Бид эхлээд өөрөө аврагдахгүй бол хүнийг аварна гэж байхгүй гэж боддог. Өөрийгөө яая гэж байж юун бусад хүний төлөө бодох гэсэн хүн ч байж магадгүй.

Гэхдээ өөрөөсөө улдаар бусад хүнийг аз жаргалтай болгоё гэсэн сэтгэл нь бурханы үйлийг хичээнгүйлэн хийж байж бий болдог юм





биш, угтаа хүн бүрт төрөлхийн байдаг сэтгэл юм.

Өөрөө төөрөлдөж, яахаа мэдэхгүй шаналж байх үед бусад хүний зовлон, шаналалыг сайн ойлгож, сэтгэлийнхээ гүнээс мэдэрдэг.

“Үнэхээр хэцүү юм болжээ”, “Ямар нэгэн аргаар туслах юмсан” гэсэн сэтгэл өөрийн эрхгүй төрнө. Тэгээд өөрийнхөө ажлыг хойш нь тавьж, тусламжийн гараа сунгадаг.

Ялангуяа эх хүн хүүхэд нь голд уначих юм бол өөрөө сэлж чадах үгүй нь хамаагүй, шууд л гол руу үсрэн орохоос зайлахгүй. Энгийнээр бодоод үзэх юм бол “сэлж чадахгүй л бол аварч чадахгүй” гэж бодох байх. Гэхдээ д үр хүүхдээ аврах юмсан гэсэн цор ганц сэтгэлээр гол руу үсрэн ордог.

Ер нь өнгөц харахад хүн бүр өөр өөр боловч сэтгэлийн гүнд орших үндсэн чанар нь адилхан. Хэн хүнгүй “Утга учиртай амьдралыг туулах юмсан”, “Аз жаргалтай болох юмсан” гэж хүсдэг. Түүнчлэн хүмүүстэй сөргөлдөөд байх биш, эв эетэй байх юмсан гэж чин сэтгэлээс хүсдэг.

Гэхдээ зүгээр суугаад байх юм бол санасны зоргоор болохгүй. Тийм болохоор л бид үргэлж бурханы сургаалыг зөвөөр ойлгон хүлээж авч, өдөр тутмын амьдралдаа тусган бодож байхыг амьдралынхаа үндэс болгодог.

Бурханы зам мөр хязгааргүй бөгөөд ингээд дууслаа гэсэн юм байхгүй. Сургаалыг жоохон ойлгосон ч гэсэн ямар нэг зүйлтэй тулгарахаар хувиа хичээсэн сэтгэл гарч ирж, уурлаж бухимдан, хэл амаа бэлүүдэх үе бий. Тэр болгондоо өөрийгөө эргэцүүлэн бодож, сэтгэлээ засаж, өдөр бүр, хором мөч бүрээс суралцаж амьдрах чухал. Энэ бол бидний хувьд бурханы зам мөр юм.

Энэ газар бол зам мөрийн газар болой буюу амьдрах гэдэг өөрөө бурханы үйл хийх гэсэн үг гэсэн зарчмаар энэ жил ч гэсэн бурханы зам мөрийг хичээнгүйлэн хэрэгжүүлцгээе.

